



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 90

Мандалговь

Хөрөнгө данснаас хасах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 2.1.7, 5.2.4, 5.8.а дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Хулд сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 13,440,000 /арван гурван сая дөрвөн зуун дөчин мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй, ДУА 3907 улсын дугаартай УАЗ-469 маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 2,000,000 /хоёр сая/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П. Очирбатад үүрэг болгосугай.

3. Худалдсан эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Хулд сумын Эрүүл мэндийн төвийн дарга Э.Уранчимэгт даалгасугай.

ДАРГА  С.БУДЖАВ

